



MONGOLIAN A1 – HIGHER LEVEL – PAPER 1
MONGOL A1 – NIVEAU SUPÉRIEUR – ÉPREUVE 1
MONGOL A1 – NIVEL SUPERIOR – PRUEBA 1

Monday 14 May 2007 (morning)

Lundi 14 mai 2007 (matin)

Lunes 14 de mayo de 2007 (mañana)

2 hours / 2 heures / 2 horas

INSTRUCTIONS TO CANDIDATES

- Do not open this examination paper until instructed to do so.
- Write a commentary on one passage only.

INSTRUCTIONS DESTINÉES AUX CANDIDATS

- N'ouvrez pas cette épreuve avant d'y être autorisé(e).
- Rédigez un commentaire sur un seul des passages.

INSTRUCCIONES PARA LOS ALUMNOS

- No abra esta prueba hasta que se lo autoricen.
- Escriba un comentario sobre un solo fragmento.

Доорхи хоёр зохиолын хэсгийг уншаад, аль нэгийг сонгож, тайлбарлан бич.

1. (a)

5 ...Монгол сайд дархан чин ван Дондубдоржид гүнжийг хатан болгож, сайдыг дайчин улсын дөрөвдүгээр тавнан “Гүрүн-и-эфү” болгох чимээ ордноо цахилгаан мэт хурдан түгэж, бага хатад гүнжийн эх Амбалингу эмэг эхэд нь баяр илтгэн ирцгээж, үеийн гүнж тэмцэлдэн баяр хүргэцгээж, “Тэр монгол сайд

10 ямар хүн бол? Залуу сайхан эр үү? Тэгвэл гүнж их заяатай ажээ. Хөгшин бөгөөд царай муутай хүн үү? Тэгвэл гүнж хөөрхий болжээ. Зарлиг дагахгүй байж үл болно. Хөгшин эрийг голох эрх ордны дотоод журамд байдаггүй” гэж шив шив шивнэлдэн, гүнжээс “Тэр хувь заяат хүнээ үзэв үү? Үзэж бараагий нь харж, дөрөвдүгээр эфүгийн байдлы нь мэдэх өдөр ойр уу?” гэж дотоод ордноо

15 өдөр тутмын уйдам тогтмол хэмжээт байдал, залхууравч зайлшгүй хэвшлээс ангид сонин явдал тохиолдсонд хатан фэй, бусад гүнж сонирхоцгоосонд, гүнж өөрөө ч сэтгэлд нь орчин олны эрхшээл нөлөө үүсэж бас л “Тэр монгол сайд нээрээ ямар хүн байдаг бол?” хэмээн үдэш өглөө бодох болж, дүр бараагий нь үзэх хүсэл төржээ.

15 Ингээд тэр хүсэлт өдөр тохиолдож монгол сайдын хатан зоригт сайхан царай зусардахыг мэдэхгүй бөгөөд бүргэд адил алсыг ширтэж сурсан ер хүнийг нэвт харж цээжин доторхи бодлыг ганц ширвэнгүүт мэдэх адил хурц харцтай маш сэргэлэн нүд, цог жавхлант сайхан тэгш бие цогцыг нь шаа хөшгийн чандаас харахдаа, өөрийн эрхгүй бахархан бас бахархсандаа ичингүйрч, ийм

20 хүнийг эзний зарлигаар сэтгэл явдлыг нь дайчин улсын төрийн бодлогонд нийцүүлэх үүрэг хүлээн авсандаа баярлах эмээх сэтгэл хослон үймэлцэж ах үес Амбалингу эмэг эхийн зүг эргэж харваас, царай дор маш сонин байдал илтгэгдэж, гүнжийн баярласанд буруушаах мэт эмээсэнд өрөвдөх мэт битүүлэг гашуунаар мишээсхийж орчлонд удаж, юм их үзсэн нүдэнд нь энгүүн өдөр

25 энхрийлдэг ач охиноо тэр өдөр их л хайрлан, төлөөнөө ийн зовнисон шинжтэй асан ажээ.

Тэр өдөр унтаар одохын өмнө гүнжийн баруун хацрыг үнсэхдээ -Төр төмөр нүүртэй шүү, хүүхэн хонгор минь гэж хэлснийг нэхэн санаваас урт насласан уужим саруул ухаант буурал эмэг эх нь хашир ухаан, хайртай

30 сэтгэлээрээ гүнжийн нас явдлын хэтийн төлөвийг зөгнөн мэдсэн ажээ.

Дөрвөн ном, таван бичиг зааж, түүний доторхи ёс журмыг тэсгэлгүй бахдан биширч хүний гол эш ёс нь тэр гэж үздэг бөгөөд, хүний чанар язгуураас сайн гэж хүнийг маш эрхэм болгодог агаад, бичиг шунаг учир эзний алба хаахгүй.Йехенара омгийн өвгөд дээдсийн буян, богд эзний хишиг миний насанд

35 бардаагаар хүрэлцэм албан тушаал, ашиг завшаан эрж орчлонгийн улаан тоосонд хутгалцалгүй сайд эрдэмтэн ихэс бичгийн хүмүүсийн бичиг зохиол үзэж, сурлага асуулгаа нэмэгдүүлж, хүн болсон хэргээ бүтээсүгэй гэж ярьдаг авга багшийн оронд нэгэн өдөр гүнжид эзний хуувийн сайд Айсан Гиоро омгийн ихэс ван, тусхайлан гүнжтэй уулзаар ирж, бишрэм инээмсэг төв байдал, эрхэм

40 ёсны үгсээр залуу гүнжийн төрд зүтгэх санааг урамшуулан хөгжүүлээд, их хүрээнээ суугаа зарлигийн манж амбан бол түүний дэд болох монгол сайд Дархан чин вангийн хатан тэр бүр уулзаж байх нь эвгүй.

Үүнд зарлигийн амбан гүнж хоёрын хооронд төрийн төмөр шижим болох нэгэн итгэмжит сайдыг гүнжийн бие сувилах эмч Дайфүүгийн тэргүүн их эмч

45 хэмээн явуулж, чухал яаралтай зүйл гарвал гүнжийн бие сувилах ховор эмийн зүйл нийслэлээс ирүүлэх нэрээр тэр гүнжийн (шадар эмчийн тэргүүн) шууд нийслэлийн газар, богд эзний хуувийн сайдууд уламжилж, харилцан тогтоох зүйлийг гүйцэтгэнэ.

Богд эзний төрийн бодлогыг гадаад аймагтаа нэвтрүүлэх зарлигийн амбан ч

50 гэсэн далдуур илэрхийгээр эзний нууц хуувийн сайд бөгөөд эмчийн тэргүүн ие

Дайфүүгийн үгнээс хэрхэвч гарах эрхгүй тул түүний үг зарлигийн адил болно. Хэрхэвч тэр нууц хуувийн сайдын заавраас зөрчиж болохгүй сүслэн дагаж гүйцэтгэн гүйцэтгүүлвээс зохино. Тэр Дайфүү эмийн зүйлийг мөн сайн төсөөлөх бөгөөд, богд эзэн ч гэсэн төрийн их нууц хуувийн сайдын үгнээс үл гарна.

55 Бас түүгээр ч үл барам, ие омогт хүн тул, гүнж чиний нагац даруй мөн гэж сүр ихэмсэг өвгөн сайдын танилцуулсан тэр их Дайфүүг санахад, яс хавтайх шиг болох ажээ.

60 Гүнжийн сэтгэл зортигтойг алхам алхмаар атгаж эрхэндээ хураасан нь, өөшинд орсон загас жараахай өөшнөөсөө гарч үл чадахын адил, хичнээн оролдовч гагц эмэгтэй хүн нарийн бодож боловсруулсан төрийн эчнээ далд аргын эрхшээлээс мултарч чадахгүй. ...

Б.Ринчин “Гүнж” 1962, “Бэр цэцэг, Гүнж” 2004 номоос

1. (b)

- Биеийн минь тодотгол:**
зорилго үүрэхдээ бух мэт гүжир
зүтгүү амгалант.
- 5 **Хэлийн минь тодотгол:**
зовлон үмхэхдээ загас мэт дуугүй
зөнгөөр амгалант.
- Сэтгэлийн минь тодотгол:**
золионд үйхдээ хонь мэт номхон
хоргүй амгалант.
- 10 **Бодохуйн минь тодотгол:**
утгын гүнд улайран шунах
уйгагүй амгалант.
- Үйлдэхүйн минь тодотгол:**
тусын ихэд тухлан шунах
туйлгүй амгалант.
- 15 **Би-**
Шивэрсэн булаг дээгүүрээ алхаж гардаггүй,
тойрч гардаг
Алжаалгүй амгалант.
- 20 **Би-**
Шивнэсэн судрын үг давхиж уншдаггүй,
гэлдэрч уншдаг
Цөхрөл үгүй амгалант.
- Би-**
- 25 Амьдад ач сэтгэхийн цагт
харам үгүй,
Баян амгалант.
- Би-**
- 30 Амьсгаан тоо гүйцэхийн цагт
харуусал үгүй,
Бардам амгалант!

Д.Урианхай “Өөрийн тодотгол” 1989, “Насны хишиг” 1991 номоос